



# ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

- [f facebook.com/Rtcc.mn0](https://www.facebook.com/Rtcc.mn0)
- [g http://rtcc.mrtd.gov.mn](http://rtcc.mrtd.gov.mn)
- [✉ info@rtcc.mrtd.gov.mn](mailto:info@rtcc.mrtd.gov.mn)
- [☎ +976 77244409](tel:+97677244409)

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2019 оны 03-р сарын дугаар

## Мэдээ, мэдээлэл



Хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгож, вагон бүртгэлийн мэдээллийн санг баяжуулан ажиллаж байна.

Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлийн програмд нийт 150 вагоны мэдээллийг 16 егэгдлийн дагуу бүртгэн оруулсан.

| Д/д | Гэрчилгээний дугаар | Бүртгэлийн дугаар | Зориулалт | Загвар | Жин/ти/ | Голын томъёо | Голын дараалт | Овор | Даац | Эзлэхүүн | Тэр |
|-----|---------------------|-------------------|-----------|--------|---------|--------------|---------------|------|------|----------|-----|
| 1   | 3974                | 560037            | xagac     | EC70A  | 24      | 4            | 23.5          | 1-BM | 70   | 88       | ZK1 |
| 2   | 3975                | 560045            | xagac     | EC70A  | 24      | 4            | 23.5          | 1-BM | 70   | 88       | ZK1 |
| 3   | 4089                | 561035            | xagac     | EC70A  | 24      | 4            | 23.5          | 1-BM | 70   | 88       | ZK1 |
| 4   | 4086                | 561043            | xagac     | EC70A  | 24      | 4            | 23.5          | 1-BM | 70   | 88       | ZK1 |
| 5   | 4084                | 561050            | xagac     | EC70A  | 24      | 4            | 23.5          | 1-BM | 70   | 88       | ZK1 |
| 6   | 3973                | 560052            | xagac     | EC70A  | 24      | 4            | 23.5          | 1-BM | 70   | 88       | ZK1 |
| 7   | 4081                | 561068            | xagac     | EC70A  | 24      | 4            | 23.5          | 1-BM | 70   | 88       | ZK1 |
| 8   | 376                 | 560060            | xagac     | EC70A  | 24      | 4            | 23.5          | 1-BM | 70   | 88       | ZK1 |
| 9   | 4083                | 561076            | xagac     | EC70A  | 24      | 4            | 23.5          | 1-BM | 70   | 88       | ZK1 |
| 10  | 3977                | 560078            | xagac     | EC70A  | 24      | 4            | 23.5          | 1-BM | 70   | 88       | ZK1 |



Шилэн дансны тухай хүүлийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх хэсэг, Шилэн дансны цахим худсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журамд заасан мэдээллийг төвийн цахим хуудас болон Шилэн дансны цахим худсанд байршуулж мэдээлж байна. Шилэн дансны цахим хуудаст байршуулах мэдээллийг цаг тухай бүрт тайлагнасан.



Стандартын төсөлд мэргэжлийн байгуулагуудаас санал аван боловсруулж ажиллалаа.

“ГОСТ 33435-2015 Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах удирдлага, хяналтын төхөөрөмж, аюулгүй байдалд тавигдах шаардлага, хяналтын арга”, “Төмөр замын мэдээллийн сан, мэдээлэл харилцаа холбооны дэд бүтцийн аюулгүй байдал” стандартын төсөлд төмөр замын байгууллагуудаас ирсэн саналыг нэгтгэн товьёог боловсруулан ажилласан байна.



Монгол орны мал сүрэг, зэрлэг ан амьтдын газар нутгийн тархац, шилжилт хөдөлгөөнд галт тэрэгний хөдөлгөөн нөлөөлөхгүй байх нөхцөлийг хангах стандартын баримт бичгүүдийг судлан ажиллалаа.

Зүүн баян - Ханги, Эрдэнэт - Овоот, Таван толгой - Гашуун сухайт, Нарийн сухайт- Шивээ хүрэн чиглэлийн төмөр замын техник эдийн засгийн үндэслэлд санал өгөх ажлын хүрээнд төмөр зам болон авто зам доогуур мал, зэрлэг ан амьтан нэвтрүүлэх „MNS 6515:2015. Тал хээр, говь цэлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага“, „MNS 6735:2018 Уулархаг нутгийн байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага“ стандартуудыг судалж байна.



УБТЗ ХНН -ийн хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийх үйл ажиллагаатай танилцлаа.

Галт тэрэгний нэгдсэн зурмагт дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд “УБТЗ” ХНН-ийн тээвэрлэлт хөдөлгөөн зохион байгуулалтын албаны захиран хуваарилах хэлтсийн өдөр тутмын ажилтай танилцах, хөдөлгөөний удирдагч ДНЦ, ДГП нарын ажлын технологийт танилцах, туршлага судлах зорилгоор ХЗХБ Хэлтсийн мэргэжилтнүүд ажиллалаа.



Авлигын шалтгаан, хор хөнөөлийг сурталчлан таниулах, авлигаас урьдчилан сэргийлэх үйлдэхүйг дэмжих ажиллагаа.

Авлигын эсрэг хууль, НАНБХАСЗАСЗУСТХ-ийг сурталчлах нь /Авлигын шалтгаан, хор хөнөөл, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа сэдвээр сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулсан.

Төвийн Авлига, ашиг сонирхлын эсрэг 2019 оны төлөвлөгөөний дагуу ажилтнуудад авлигын хор хөнөөлийг таниулах, авлигыг үл тэвчих ухамсырыг бий болгох, мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан “Авлигын хор хөнөөл” сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг амжилттай зохион байгуулсан. Тус уралдаанд төвийн мэргэжилтнүүд идэвхтэй оролцож, бүтээлээ ирүүлснээс 1-р байранд ТМССХ-ийн мэргэжилтэн Г.Баттөр, 2-р байранд ТМССХ-ийн мэргэжилтэн О.Эрдэнэтулга, 3-р байранд ТМССХ-ийн мэргэжилтэн Б.Жавзандулам нар шалгарч, өргөмжлөл, дурсгалын зүйл, мөнгөн шагналаар урамшууллаа.




Төвийн спортын 5 төрөлт тэмцээн зохион байгуулагдлаа.

ТМССХ-ээс санаачлан төвийн ажилчдын дунд зохион байгуулсан спортын 5 төрөлт тэмцээнийг зохион байгуулж, аваргуудаа шалгаруулсан.





## Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бурдүүлэн ажиллаж байна



2019 оны 3 дугаар сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа болон зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч болон ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны [www.mrtd.gov.mn](http://www.mrtd.gov.mn), төвийн [www.rtcc.mrtd.gov.mn](http://www.rtcc.mrtd.gov.mn) цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ.

“Тээврийн салбарын 2018 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт”, 2017, 2018 оны “Маягт №ТЗ-3 Төмөр замын байгууллагын ажиллагчдын тоо, ажилласан жил, боловсролын түвшний жилийн мэдээллийн нэгтгэл”-ийг гарган Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын статистик хариуцсан мэргэжилтэнд цахим хэлбэрээр хүргүүлсэн.

Зам, тээврийн хөгжлийн яамны ТЗДТБХЗГ-т “Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-д хийх үнэлгээний тоо баримтад шаардагдах мэдээллийг гарган цахим хэлбэрээр хүргүүлсэн.



## Төмөр замын холбогдолтой гадаад улсын сэтгүүлийн 02-р сарын дугаарыг төвийн цахим хуудсанд байршууллаа

Гадаад орнуудын төмөр замын салбартай холбоотой “Railway Age”, “Trains” “Railway Magazine” сэтгүүлийн 03-р сарын дугаарыг харах болон татаж авах форматад хөрвүүлэн төвийн [www.rtcc.mrtd.gov.mn](http://www.rtcc.mrtd.gov.mn) цахим хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэлээ.



## Авлигын хор хөнөөл

Авлига гэж юу вэ? Хүмүүс бидний дунд нийгмийн харилцааны энэ шударга бус, хүнд хэлбэр оршсоор байгаа, хэрхэн үндэслэж хөгжин цэцэглэдэг, нийгэмд яаж нөлөөлдөг, хэрхэн тэмцэх тухай өгүүлэх энэхүү эсээгээрээ би хээл хахууль, авлигын хор хөнөөлийг тодорхой жишээгээр хүүрнэн бичих гэж бодолд автлаа.

Миний санаж мэдэхээр хүний нийгмийн бүх он цаг мөчүүдэд оршсоор ирсэн хорт үзэгдлийн талаар хамгийн анх сэргж мэдсэн тохиол бол “Зэрэг нэмэхийн өмнө” гэх Монголын уран сайхны кино бөгөөд хээл хахууль авлгын тухай дүрслэн үзүүлдэг дэлгэцийн бүтээл юм. Уг кинонд хошууны тайж Богд хаанд их өргөл барьц барьж “гүн” цол хэргэм горилох зорилгоор хоёр зарцын хамт нутгаасаа гарч нийслэл хүрээ орох аян замдаа туулсан инээдэмтэй үйл явдалууд, эцэс төгсгөлд нь зэрэг жинс нэмүүлэх боломжко алдаж байгаа тухай гардаг. Энэ кинонд гарч байгаа үйл явдлыг шинжилвэл тухайн үеийн язгууртан угсааны хүн өргөмжит цол нэмүүлэх, шан харамж авахын тулд одоогийн нэршлээр албан тушаалын авилгын хэрэг үйлдэх гэж байгаа нь авилгын асуудал орчин үед гарч байгаа асуудал биш эрт цагт ч гарч байсан үзэгдэл гэдгийг харуулдаг. Хэрэв гол дүрийн тайж “гүн” цол авсан бол ямар хор уршиг гарах байсан бол гэдэг нь анхаарууштай сэдэв юм. Хувь хүний хөгжил төлөвшил хомс, аливааг дүгнэн тунгаан бодох чадваргүй хүн төрийн хэргийг хаших болж хошуу нутгийн хүн ардын аж амьдрал улам доройтох асуудал үүсч болох байсан. Энэ бүх зүйлээс урьдчилан сэргийлэхээр киноны гол дүрүүдийн нэг Боролдой ард олны захиасыг биелүүлж, тайжийн авилга өгөхүйлдэхүйд хэрхэн саад тоттор учруулж, хэргэм цол нэмүүлэх үйлдлийг таслан зогсоосноор уг киноны гаргалгаа учиг тайлагдана. Үүнээс үзэхэд авлигын хор хөнөөлийг дүгнэх, хэрхэн тэмцэх талаар харуулсан жишээнүүдийн нэгийг л уран сайхны аргаар дүрслэн үзүүлж, үзэгч олонд сургамжилжээ.

Одоо үед авлигын хэлбэр олширч, улс орон, нийгэм эдийн засагт учруулах хор хөнөөл нь Монгол хүний эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах, суралцах эрхтэй гэсэн идейд сэргээр нөлөөлж байна. Хамгийн наад захын жишээ нь монгол хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй гэртээ өнжих, гурван ээлжээр хичээллэдэг сургуулиуд байсаар боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг ижил тэгш хүртээмжтэй авч чадахгүй, агаарын ба хүрээлэн буй орчны бохирдол нэн их, газар олголтыг шударга бус хийснээр хотын төлөвлөлт, зохион байгуулалт илт муудсан, хууль сахиулах институцуудэд шалгагдаж байгаа хэргүүдийн зарим цөөн нь хэрэг үйлдэгчдийн талд илтээр шийдэгдэж, бүтээн байгуулалтын ажлын тендерийн шалгаруулалтад авилга, ашиг сонирхлын зөрчил ил далд хэлбэрээр олширч, үндсэндээ салбар бүрт халдварт өвчин адил тархсан байна.


Олон улсын “Транспаренси интернейшнл” байгууллагын авлигын үнэлгээгээр 2018 онд Монгол улс 37/100 оноотойгоор дэлхийн 180 орноос 93-т жагсаж, эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтийг илтгэх индексээр 55.4/100 оноогоор 180 орноос 126-д нилээн хойгуур жагсаж дэлхийн дундаж индексээс доогуур оноо авсан. Төрийн удирдлагын тогтолцоонд авлигатай тэмцэх газар байдаг ч үйл ажиллагааны хараат байдал нь хангалттай бус, улс төрчдөөс хамааралтай ба улс төрийн хүчинүүдийн хариуцлагагүй байдал, ёс зүйн хэм хэмжээг зөрчин байгаа үйлдлүүд нь улсын болон орон нутгийн сонгуулийн үр дүнд бий болсон хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх засаглалын үндсэн үүргээ хууль ёсны дагуу хэрэгжүүлэх чадамжгүй болгож байна.

Нөгөө талаас ард иргэдийн улс төрийн оролцоонд баримтлах чиг хандлага ямар хэмжээнд байгаа нь илт. Шуудхан хэлэхэд ходоодоороо саналаа өгөх, бэлэн тараасан эд зүйлсээр саналаа худалдах гэдэг зүйл газар авсан үзэгдэл болж нийтлэг тохиолдох боллоо. Үүний үр дүнд дээр дурьдсан хүндрэл бэрхшээлүүд тулгарч, энэ бүх зүйл нь эргэх холбоонд орж сүүлийн хэдэн сонгуульд давтагдлаа. Нэгэн эрхмийн хэлснээр “Мөнгө ярьж эхлэхэд үнэн дуугаа хураадаг” гэсэн далд утгатай хэлц үг биелэлээ олсон нь энэ ажгуу. Үүнийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй ба бүгдийг нь даван туулж гарахын тулд одоогийн нөхцөл байдалд хэрхэн дүн шинжилгээ хийн, дор бүрнээ ухамсарлаж, хариуцлагатайгаар хандах улс төрийн оролцооны зарчмаа тодорхойлох, цаашлаад улс эх орныхоо язгуур эрх ашгийг хамгаалах үйлсийг түгээн дэлгэрүүлэх ажлыг санаачилж хэрэгжүүлвэл зохилтой.




2019 оны 3 дугаар сард өссөн дүнгээр зорчигч тээвэрлэлт 562.6 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 9.2%-иар буурсан, ачаа тээвэрлэлт нь 6582.1 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 7.1%-иар өссөн үзүүлэлттэй байна.


## ИНФОГРАФИК




## Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт



Зорчигч тээвэрэлт 2019 оны гуравдугаар сард 182.6 мян.зорчигч тээвэрлэсэн, ачаа тээвэрэлт нь энэ сарын байдлаар 2228.6 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.

Ачилт- ачааны төрлөөр  
/2019 оны 3 дугаар сард/

## Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/



Дамжин өнгөрсөн ачаа 2019 оны гуравдугаар сард 298.5 мян.тн ачсан байна.

Ачилтаар 2019 оны гуравдугаар сард төмрийн худэр, нүүрс, барилгын материал, жонш, зэс, молибдений баяжмал, нефтийн бүтээгдэхүүн өссөн үзүүлэлттэй байна. Нийт 1955.7 мян.тн ачсан байна.

|                         |     |
|-------------------------|-----|
| Төмрийн худэр           | 43% |
| Нүүрс                   | 34% |
| Бусад ачаа              | 8%  |
| Барилгын материал       | 7%  |
| Жонш                    | 3%  |
| Зэс, молибдений баяжмал | 3%  |
| Нефтийн бүтээгдэхүүн    | 2%  |



 8-р давхар, Хан-Уул цамхаг,  
Б.Шаравын гудамж 6,  
З-р хороо, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар хот 17042, Монгол Улс

